

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2013-2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн тухай

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын төлөвлөгөө, харьяа болон орон нутгийн байгууллагуудын 2013-2014 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх болон санхүүгийн хяналт-шалгалт явуулах тухай Эрүүл мэнд, спортын сайдын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2013-2014 оны төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт, санхүүгийн үйл ажиллагаанд 2015 оны 03 сарын 30-ны өдрөөс эхлэн ажлын 15 хоногт шалгалтыг хийв.

Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нэгдсэн төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага, стандартын хүрээнд үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөлт, түүний гүйцэтгэл, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, түүний үр дүн, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт зэрэг шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өглөө.

УИХ-ын 2012 оны 8-р сарын 17-ны өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” 14-р тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн “Эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулах тухай” 50 дугаар тогтоолуудын дагуу Эрүүл мэндийн сайдын 2012 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 320 тоот тушаалаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, орон тоог тус тус тогтоож баталсаны дагуу 2014 оны байдлаар үндсэн 54, гэрээт 18 ажилтан ажиллаж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эрүүл мэндийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, МУ-ын ЗГ-ын эрүүл мэндийн салбарын талаархи бодлогыг хэрэгжүүлэх, Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулах үүрэг хариуцлагыг хүлээж, эрүүл мэндийн байгууллага болон эмнэлгийн мэргэжилтнийг хөгжүүлэх, эрүүл мэндийн салбарт шинэ технологи нэвтрүүлэх, эрүүл мэндийн статистикийн мэдээллийг боловсронгуй болгох, телемедициний сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, мэдээллийг боловсронгуй болгох чиглэлээр хууль тогтоомж, эрүүл мэнд, спортын яамны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хангуулах чиг үүрэгтэй ажиллаж байна.

шалгалтыг цахимжуулж, сард 2 удаа авдаг болсон. Мөн 2014 онд АШУҮИСургуулийг төгссөн 2425 оюутан зөвшөөрлийн шалгалт өгсөнөөс 40% нь дахин шалгалтанд орсон зэрэг нөлөөлжээ. Туслах үйл ажиллагааны орлого дутсан шалтгаан нь эмч нарын байранд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар засвар хийх болсон тул байрлагчдыг түр гарган байрыг чөлөөлсөн байна.

2013 онд 466,0 төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлого давсан шалтгаан нь эмч нарын байрны орны тоог нэмэгдүүлсэн байна.

Төсөл, хөтөлбөрийн арга хэмжээ:

Тус төв нь 2013 онд нэмэлт санхүүжилтийн дансанд /900020405/ Сангийн яамны 2012.12.28-ны 295-р тушаалаар төвлөрүүлсэн 2012 оны төсөл арга хэмжээний зарцуулагдаагүй үлдэгдэл болох 8.981,4 мянган төгрөг, Глобаль сангаас улирлын мэдээ боловсруулж, хэвлүүлэх, хяналт үнэлгээ хийх, БЗДХ/ДОХ сүрьеэгийн бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах сургалт, эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтнүүдийн чадавхи бэхжүүлэх сургалт зэрэг үйл ажиллагааны санхүүжилт болох 97.604,7 мянган төгрөг, ЭМЯамнаас ЭМ-ийн сайдын 2013.03.14-ны 80 тоот тушаалын дагуу эрчүүдийн үзлэг хийх болон STATA программын зардалд 2.579,5 төгрөг, Эрүүл мэндийг дэмжих сангаас “Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах” сэдэвт сургалт, уламжлалт эмийн нэр томъёо ангилалын стандартын төсөл боловсруулах, эмч нарын гадаад сургалт зэрэг үйл ажиллагааны зардалд нийт 156.053,9 мянган төгрөг, Сангийн яамнаас Сангийн сайдын 157 дугаар тушаалаар урьд оны төсвийн хэмнэлт болох 27.618,6 мянган төгрөгийн санхүүжилт тус тус орсоноос үйл ажиллагаандаа зарцуулагдаж жилийн эцсийн байдлаар 2013 оны 4-р улирлын мэдээлэл боловсруулах, уламжлалт эмийн нэр томъёо ангилалын стандартын төсөл боловсруулах зэрэг ажлын үлдэгдэл 4.668,8 төгрөг энэ дансанд үлдсэн байна.

2014 онд Глобаль сангаас улирлын мэдээлэл боловсруулж хэвлүүлэх зардалд 2.096,2 мянган төгрөг, ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнүүдэд хийх сургалтанд 30.682,6 мянган төгрөг, ЭМС-ын статистик мэдээлэлд хяналт, үнэлгээ хийх зардалд 4.769,8 мянган төгрөгийн санхүүжилт тус тус орсоноос 37.809,2 мянган төгрөг нь үйл ажиллагаандаа зарцуулагдаж 55,2 мянган төгрөг үлджээ.

ДЭМБ-аас эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шалгалтын сорил сонгосон багш нарын ажлын хөлс болох 10.425,0 мянган төгрөг, Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг боловсронгуй болгох нь сэдэвт уулзалтын зардалд 2.827,0 мянган төгрөг, Амилуулах тусламжийн интерактив видео хичээл бэлтгэх ажилд 3.825,0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус орсон ба бүрэн зарцуулагдсан байна.

Сангийн сайдын 143 тоот тушаалаар урьд оны төсвийн урамшуулалд 73.113,4 мянган төгрөг авсан ба байгууллагын хамт олны ажлын үр дүнг харгалзан урамшуулах, ажиллагчдын нийгмийн асуудал болон байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалттай хөрөнгө, урсгал засвар зэрэгт зарцуулсан байна.

2.2 Төсвийн зардлын гүйцэтгэлийн талаар

Эрүүл мэндийн хөгжлийн төвд 2013 онд 2.423.803,0 мянган төгрөгийн төсөв батлагдаж төсвөөс 2.410.974,3 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 2.389.954,4 төгрөгийн зарлага гаргаж, нийт төсөвт зардлыг 21.019,8 мянган төгрөгөөр хэмнэсэн бол 2014 онд 2.559.076,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2.533.379,6 мянган төгрөгийн зарлага гаргаж батлагдсан төсөвт зардлыг 25.696,3 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулжээ.

/мянган төгрөг/

Зардлын зүйл	2013 онд			2014 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт
Урсгал зардлын дүн	2,423,803.0	2,389,954.4	33,848.6	2,559,076.0	2,533,379.6	25,696.3
Үндсэн цалин	529,493.4	529,073.6	419.7	575,428.8	575,428.8	
Унаа хоолны хөнгөлөлт	104,493.3	104,493.3		101,747.7	101,747.7	
Нийгмийн даатгалын шимтгэл	69,738.8	69,738.8		74,489.5	74,489.5	
Гэрэл цахилгаан	21,200.2	26,570.2	-5,370.0	19,786.8	26,154.7	-6,367.9
Түлш, халаалт	38,963.5	21,104.4	17,859.1	37,267.1	18,867.6	18,399.5
Цэвэр, бохир ус	16,648.8	9,502.2	7,146.6	8,629.3	9,519.4	-890.1
Бичиг хэрэг	9,896.1	8,046.3	1,849.8	15,599.9	11,878.6	3,721.3
Тээвэр, шатахуун	42,345.1	42,287.8	57.3	29,427.0	28,730.8	696.2
Ном хэвлэл авах	950.0	312.8	637.2	855.0	121.9	733.1
Шуудан, холбоо	8,822.4	8,994.2	-171.9	7,466.1	13,032.3	-5,566.2
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	4,200.0	3,165.4	1,034.5	4,200.0	6,874.3	-2,674.3
Дотоод албан томилолт	38,149.0	36,310.3	1,838.7	25,536.8	23,495.9	2,040.9

Гадаад албан томилолт	5,000.0	4,993.1	6.8	3,000.0	4,440.3	-1,440.3
Төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх зардал	1,445,216.0	1,445,082.5	133.5	1,557,968.0	1,555,981.2	1,986.8
Урсгал засвар	20,000.0	19,759.0	241.0	29,818.4	29,706.4	112.0
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	11,000.0	11,000.0	-464.4	11,000.0	10,738.0	262.0
Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	6,880.4	5,766.1	1,114.3	12,419.2	8,133.0	4,286.2
Тээврийн хэрэгслийн даатгал	3,281.0	650.9	2,630.1	2,881.0	861.7	2,019.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	185.0	175.1	9.9	185.0	148.5	36.5
Мэдээлэл, сурталчилгааны зардал	27,480.0	26,899.1	580.8	23,815.9	18,808.4	5,007.5
Нэг удаагийн буцалтгүй тусламж, шагнал урамшил	3,225.0	5,286.6	-2,061.6	705.3	705.3	
Газрын төлбөр	750.0	555.9	194.1	750.0	562.5	187.5
Тээврийн хэрэгслийн татвар	307.0	307.0		707.0	630.4	76.6
Хог хаягдал устгах, цэвэрлэх	3,078.0	2,310.1	767.9	3,078.0	2,653.2	424.8
Маягт хэвэлх зардал	10,000.0	7,105.0	2,895.0	8,000.0	8,8187.9	-187.9
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс	2,500.0		2,500.0	2,500.0	372.2	2,127.8
ЗАРДЛЫГ	2,423,803.0	2,392,954.4	30,848.6	2,559,076.0	2,579,442.4	-20,366.4

САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР						
Үндсэн үйл ажиллагааны орлого	61,284.0	96,596.3	-35,312.3	79,200.0	114,363.6	-35,163.6
Туслах үйл ажиллагааны орлого	24,470.4	77,214.9	-52,744.5	65,532.0	65,557.8	-25.8
Төсвөөс санхүүжих	2,325,219.9	2,219,143.2	106,076.7	2,414,344.0	2,396,520.8	17,823.2

Төсвийн гүйцэтгэлийг авч үзвэл: 2013 онд нийт төсөвт зардлын 29 хувь буюу 703.7 сая төгрөгийг цалин хөлс, түүнээс тооцсон нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, 59.6 хувь буюу 1,445.2 сая төгрөгийг төрийн албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх зардлууд эзэлж, үлдэх 11.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардлууд эзэлж байна. 2014 онд нийт төсөвт зардлын 29.4 хувь буюу 751.6 сая төгрөгийг цалин хөлс, түүнээс тооцсон нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, 60.8 хувь буюу 1,558.0 сая төгрөгийг төрийн албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх зардлууд эзэлж, үлдэх 9.8 хувийг бараа үйлчилгээний бусад зардлууд эзэлж байна.

Зардлын зүйл ангиар авч үзвэл: 2013 онд гэрэл цахилгаан, шуудан холбоо, төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, нэг удаагийн буцалтгүй тусламж зэрэг зардлууд 171.9-5,370.0 мянган төгрөгөөр, 2014 онд гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, шуудан холбоо, интернэтийн зардал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, гадаад албан томилолт, улсын мэдээллийн маягт хэвлэх зэрэг зардлууд 187.9-6,367.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

2013, 2014 онд гэрэл цахилгаан, цэвэр, бохир усны зардал хэтэрсэн нь цахилгаан, усны үнэ нэмэгдсэнтэй холбоотой. Харин тус онуудад түлш халаалтын зардал хэмнэгдсэн шалтгаан нь автомашины граш барих ажил хойшлогдсонтой холбоотой.

2013-2014 онуудад батлагдсан төсвийг нийт дүнгээр нь хэмнэлттэй зарцуулж, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан байна.

Хөдөө орон нутагт ажилладаг эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагааг тус төв зохион байгуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдэнд зориулан төрөөс олгож байгаа тэтгэлэг, сургалтын зардлыг тус төвөөр дамжуулан санхүүжүүлж байна.

2013 онд төсвийн хөрөнгөөр 5.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 18.9 сая төгрөг, Мянганы сорилын сангийн хөрөнгөөр 8.9 сая төгрөгийг бүртгэлд аван, 140.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хорооны шийдвэрийн дагуу данснаас хасан акталж устгасан байна.

2.3 Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт

/мянган төгрөгөөр/

Үндсэн хөрөнгө	2013 он		2014 он
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Барилга байгууламж	3,209,220.7	3,209,220.7	3,349,023.8
Авто тээврийн хэрэгсэл	2,096,202.9	1,958,145.5	500,315.0
Тоног төхөөрөмж	472,184.7	402,505.0	966,771.6
Тавилга хэрэгсэл	244,075.7	213,850.0	213,591.1
Бусад үндсэн хөрөнгө	7,368.4		
Программ хангамж	26,987.4	26,987.4	32,177.3
Бусад биет бус хөрөнгө	32,295.5	32,295.5	32,295.5

2013 онд 138,057.3 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг ТӨХ-ны 25-р тогтоол болон ЭМЯ-ны 1а/299 тоот тушаалыг үндэслэн балансаас балансад шилжүүлсэн байна.

2014 онд АТТ-ын үйлчилгээ төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд шилжсэнтэй холбоотой Төрийн өмчийн хорооны 466 тоот тогтоолын дагуу ГССҮТ, ХӨСҮТ, УГТЭ, УНТЭ, ЭХЭМҮТ, Дархан Нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудад 1,460,406.3 мянган төгрөгийн автомашин, тавилга, тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн хасаж бүртгэсэн байна.

2014 онд эмч нарын байранд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 139,803.1 мянган төгрөгийн их засварын ажил хийснийг барилга байгууламж дансны үнийг нэмэгдүүлэн бүртгэж, мөн 547,135.3 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгөөр 1,769.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 1.055.0 мянган төгрөгийн тавилга тус тус тавилга орлогод авсаныг данс бүртгэлд тусгасан байна.

ДҮГНЭЛТ

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай

хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад, хууль тогтоомжийн дагуу явагдаж ирсэн байна.

2. Тус төв нь өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тогтмол хийж ажилласанаар төсвөөс олгосон мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу жил бүр хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж ирсний зэрэгцээ өр, авлаггүй ажиллажээ.

3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүү нь анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж, баримтын бүрдүүлэлт, боловсруулалтыг батлагдсан заавар, журмын дагуу хийжээ.

4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцлийг Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын дагуу гаргаж холбогдох байгууллагуудад нь хуулийн хугацаанд тайлагнаж иржээ.

5. Үндэсний аудитын газраас ЭМХТ-ийн 2013, 2014 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт гарсан байна.

6. ЭМХТөв нь 2010 онд Эрүүл мэндийн яамнаас гаргасан “Эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж, санхүүгийн Acolous программыг санхүү, НББ-ийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, эд хөрөнгийн тооллогын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн техник үйл ажиллагааг багасгаж програм хангамж шинээр хийлгэн ашиглаж байгаа нь бүртгэлийн үйл ажиллагаанд томоохон дэвшил гарахуйц ажлыг хийсэн байна.

Цаашид дараах асуудлуудад анхаарч ажиллах нь зүйтэй.

1. Аж ахйн нэгж байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээг тогтмол дүгнэж, гэрээний хэрэгжилт, биелэлтэнд тогтмол хяналт тавьж байх

2. Эмч нар байрладаг байрны байрлагсдын өдөр тутмын бүртгэлийг сайжруулах, байрны дотоод журмыг боловсронгуй болгох, байрлагсадтай хийх гэрээг боловсронгуй болгож архивт шилжүүлэх.

ХШҮДАГ

Ажлын хэсэг